



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/828

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбогдуулан шинээр боловсруулах дүрэм, журам, шийдвэрийн жагсаалтыг нэгдүгээр, нийслэлийн болон нийслэл хотын хэрэгжүүлэх зохицуулалт бүхий чиг үүргийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамжийн 1 дүгээр хавсралтад заасан асуудлыг судалж, холбогдох дүрэм, журам, шийдвэрийн төслийг боловсруулж 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг хариуцан боловсруулах байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн 2 дугаар хавсралтад заасан болон хуульд заасан нийслэлийн болон нийслэл хотын чиг үүрэгт хамаарах асуудлыг судалж шинэчлэх, шинээр боловсруулах шаардлагатай зохицуулалт (дүрэм, журам, заавар, стандарт гэх мэт)-ын төслийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.

4. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, эдгээр хуулийг дагалдан гарсан хууль тогтоомжийн шинэлэг зохицуулалтыг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийг дагаж мөрдөх бэлтгэл ажлыг хангаж, хийсэн ажлын талаарх тайланг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг дүүргүүдийн Засаг дарга, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Шинээр батлагдсан хууль тогтоомжийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр сурталчлах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэлтэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул)-т даалгасугай.

6. Энэ захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Т.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

1110200003848

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
 10 сарын 22-ний өдрийн
 А/828 дугаар захирамжийн
 1 дүгээр хавсралт

ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ ДҮРЭМ, ЖУРАМ, ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Дүрэм, журам, шийдвэрийн нэр, агуулга	Батлах субъект	Хууль зүйн үндэслэл	Хариуцан боловсруулах байгууллага	Оролцох байгууллага
Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль					
1	Нийслэл хотын эдэлбэр газрыг тогтоох	НИТХ	6 дугаар зүйлийн 6.2 дэх хэсэг	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ
2	Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт	Засгийн газар	6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ, Нийслэлийн Татварын газар, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар
3	Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрэм	НИТХ	6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ, Нийслэлийн Татварын газар, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар
4	Нийслэл хотын бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам	НИТХ	7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг	НЗДТГ-ын ТЗУХ	
5	Нийслэл хотын дүрэм	НИТХ	9 дүгээр зүйл	НЗДТГ-ын ХЭЗХ	Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
6	Хуульд заасан хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээ тогтоох	НИТХ	16 дугаар зүйлийн 16.2, 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалт	НЗДТГ-ын СТСХ, Нийслэлийн Татварын газар	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба

7	Нийслэл хотыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам	НИТХ	17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг	НЗДТГ-ын ХБТХ, ТХХЗХ	НЗДТГ-ын СТСХ, ХЭЗХ
8	Нийслэл хотыг хөгжүүлэх зорилготой Хөрөнгө оруулагчдын Зөвлөл байгуулах, бүрэлдэхүүн, ажиллах журам	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг	НЗДТГ-ын ХБТХ, ТХХЗХ	
8	Нийслэл, дүүргийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг нутгийн захиргааны бусад адилтгах албан тушаалын ангилал зэрэглэлээс өөрөөр тогтоох	Засгийн газар	20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг	НЗДТГ-ын ТЗУХ, ХНУТ	
9	Нийслэл хотын нийтийн эдэлбэрийн газрын хэмжээг тогтоох, ашиглалтын журам	НИТХ	21 дүгээр зүйлийн 21.1.4 дахь заалт	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
10	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоох	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	22 дугаар зүйлийн 22.1.8 дахь заалт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба	
11	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид зөвлөх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, бүрэлдэхүүн, ажиллах журам	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалт	НЗДТГ-ын ТЗУХ	

12	УБЗАА-ны бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох	Засгийн газар	25 дугаар зүйлийн 25.1 дахь хэсэг	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, НЗДТГ-ын ТЗУХ, ХНУТ	
13	Дүүргийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох	Засгийн газар	30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг	НЗДТГ-ын ТЗУХ, ХНУТ	Дүүргүүдийн ЗДТГ
14	Нийслэл хотыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, үр дүнд хүрсэн иргэн, хуулийн этгээдийг шалгаруулах, дэмжих, урамшуулах журам	НИТХ	33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
15	Дагуул хот байгуулах /нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил/	УИХ	35 дугаар зүйл	НЗДТГ-ын ХБТХ, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ
16	Дагуул хотын дүрэм	Засгийн газар	34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэг	НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
17	Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс байгуулах /газар нутгийн хэмжээ, байршил/	Засгийн газар	38 дугаар зүйлийн 38.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг	НЗДТГ-ын ХБТХ, ТХХЗХ, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ
18	Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	НИТХ	40 дугаар зүйлийн 40.2 дэх хэсэг	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ
19	Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг урамшуулах, татварын бус дэмжлэг үзүүлэх журам	НИТХ	43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэг	НЗДТГ-ын ХБТХ, ТХХЗХ	НЗДТГ-ын СТСХ, ХЭЗХ

20	"Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журам	НИТХ	48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг	НЗДТГ-ын ТЗУХ	
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/					
21	Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам	НИТХ	24 дүгээр зүйлийн 24.1.9, 35 дугаар зүйлийн 35.1.16 дахь заалт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба	Дүүргүүдийн ЗДТГ
22	Хотын стандарт	НИТХ	24 дүгээр зүйлийн 24.1.15, Монгол Улсын нийслэлийн Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйл	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар	Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
 10 дугаар сарын 22-ний өдрийн
 А/БЗД/ дугаар захирамжийн
 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН БОЛОН НИЙСЛЭЛ ХОТЫН
 ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ЖАГСААЛТ

д/д	Гарах шийдвэрийн агуулга	Батлах субъект	Хууль зүйн үндэслэл	Хариуцан боловсруулах байгууллага	Хамтрах байгууллага
Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль					
1	Нийслэл хотын хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт	НИТХ	8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Нийслэлийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар, Дүүргийн ЗДТГ
2	Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зохицуулалт	НИТХ	8 дугаар зүйлийн 8.3.9 дэх заалт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба	Дүүргийн ЗДТГ, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ
3	Гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт	НИТХ	8 дугаар зүйлийн 8.3.10 дахь заалт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба	НЗДТГ-ын ХМХХ, Дүүргийн ЗДТГ
Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/					
4	Нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт	НИТХ	24 дүгээр зүйлийн 24.1.11 дэх заалт	Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар	НЗДТГ-ын ХБТХ
5	Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт	НИТХ	24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалт	Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар	НЗДТГ-ын ХБТХ, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв
6	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт	НИТХ	24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар, Нийслэлийн Орон сууц, дэд бүтцийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/298

Улаанбаатар хот

Дүрэм, журам, шийдвэрийн
төслийг боловсруулж, танилцуулах үүрэг бүхий
ажлын хэсэг байгуулах тухай


Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" А/828 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2, 2.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбогдуулж Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/828 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан болон бусад шинэчлэх, шинээр батлуулах шаардлагатай дүрэм, журам, шийдвэрийн төслийг боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр, дэд ажлын хэсгийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус байгуулсугай.

2. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/828 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан шийдвэрийн жагсаалтын 10, 21, 2 дугаар хавсралтаар батлагдсан үүргийн жагсаалтын 1-т заасан шийдвэр, чиг үүргийг хэрэгжүүлэх төслийг боловсруулж энэхүү тушаалын 3 дугаар зүйлд заасан хугацаанд танилцуулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/232 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг /Т.Золжаргал/-т даалгасугай.

3. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/828 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн төслийг боловсруулж Хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд 2021 оны 11 дүгээр сард багтаан, захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан жагсаалтад тусгагдсан холбогдох зохицуулалтын баримт бичгийн төслийг боловсруулж Хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд 2022 оны 2 дугаар сард багтаан танилцуулж, Нийслэлийн засаг

даргын захирамжийн заасан хугацаанд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах бэлтгэл хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Ц.Рэгзэдмаа)-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 онь 11 сарын 01 өдрийн
А/298 тушаалын 18/11 хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаа
- Гишүүд:
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсүрэн
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Т.Хэрлэн
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн дарга М.Гансэлэм
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга С.Аригуун
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Золжаргал
 - Дүүргүүдийн Дэд бүтэц, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Уянга

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 11 сарын 01 өдрийн
11238 тушаалын дүгнэлт хавсралт

1.ИНЖЕНЕР ХАНГАМЖ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ДҮРЭМ, ЖУРАМ ХОЛБОГДОХ
БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Т.Хэрлэн

Гишүүд:

УБДС ТӨХК-ийн дэд захирал Б.Батбаяр

ОСНААУГ-ын дэд дарга Г.Гантулга

УБЦТС ТӨХК-ийн Техникийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Б.Аззаяа

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Л.Алтангэрэл

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн Д.Сүхбат

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн И.Баасансүрэн

Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлийн гүйцэтгэх захирал М.Галбаатар

Хувийн орон сууц нийтийн аж ахуйн хөгжлийн төв" ТББ-ын гүйцэтгэх захирал Л.Мөнхбаяр

Орон сууц нийтийн аж ахуйн мэргэжлийн холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал П.Түвдэндорж

Дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга нар

Нарийн бичгийн дарга:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн Тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Оюунтөгс

2.ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ДҮРЭМ, ЖУРАМ
ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн дарга М.Гансэлэм
Гишүүд:	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Сүхбат
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Л.Булган
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Д.Батзориг
	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга Ж.Гал
	Хот байгуулалт, хөгжлийн газрын Хот төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Батцолмон
	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Н.Билэгсайхан
	Нийслэлийн Соёл урлагийн газрын Соёлын хэлтсийн Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн М.Мөнхсайхан
	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Баатарсүрэн
	Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр
	Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлийн гүйцэтгэх захирал М.Галбаатар
Нарийн бичгийн дарга:	Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Тохижилтын бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ш.Чанцалнурмаа

3. ХОГ ХАЯГДАЛ, ОРЧНЫ БОХИРДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР
ДҮРЭМ, ЖУРАМ ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДЭД
АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга С.Аригуун

Гишүүд: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Хог хаягдлын бодлогын асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн Т.Энх-амгалан

Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон холбоо Төрийн бус байгууллагын тэргүүн Б.Жаргал

Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн Төрийн бус байгууллагын тэргүүн А.Нямдорж

Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал, хөгжлийн хүрээлэн Төрийн бус байгууллагын тэргүүн А.Мягмардолжин

Швейцарийн хөгжлийн агентлагийн Улаанбаатар хотын хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежемент төслийн зөвлөх Б.Дэлгэрбаяр

Буяны зан үйлийн холбоо төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Р.Оюунгэрэл

Монголын халдваргүйтгэл, ахуйн шавьж мэрэгчтэй тэмцэх холбоо төрийн бус байгууллагын нарийн бичгийн дарга С.Баасанжав

Монголын Шинжлэх ухааны академийн Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хөрс судлаач П.Оюунбат

Азтай савар амьтанд хайртай залуус Төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон

Нарийн бичгийн дарга:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага зохицуулалтын хэлтсийн Хөрсний бохирдол хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхбаяр

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Тусгай хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Шийтэр

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэр, төвлөрсөн хогийн цэг хариуцсан мэргэжилтэн Г.Индарьяа

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхжаргал

БАТЛАВ
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА *[Signature]* С.ГАНТӨМӨР

2021 оны 11 сарын 08-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021.10.22-НЫ ӨДРИЙН А/828 ДУГААР ЗАХИРАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ШИНЭЧЛЭХ, ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ДҮРЭМ ЖУРАМ, НИЙСЛЭЛ ХОТЫН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ.

2021 оны 11 сарын 08.

Улаанбаатар хот

Д/д	Шинээр боловсруулах дүрэм журам, шийдвэр, зохицуулалт хийх баримт бичгийн нэр	Хууль зүйн үндэслэл, заалт	Баримт бичгийн төрөл	Батлах субъект	Хариуцан боловсруулах дэд ажлын хэсэг, хамтрах байгууллага	ХЕМ-ийн зөвлөлд танилцуулах хугацаа	Тайлбар
НЭГ. ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ ДҮРЭМ, ЖУРАМ, ШИИДВЭРИЙН ЖАГСААЛТ							
1.	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ААНБ-ын ажиллах цагийн хуваарийг тогтоох	МУНУБХЭЗБТХ-ийн 22 дугаар зүйл. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрх 22.1.8. нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоож, мөрдүүлэх.	Захирамж	НЗД	ХЕМ-ийн 2021 оны А/232-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг		НЗД-ын 2021 оны Цагийн хуваарь шинэчлэн тогтоох тухай А/739 захирамж гарч 2021 оны А/590 дүгээр захирамж хүчингүй болсон.
2.	УБЗАА-ны бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох	25 дугаар зүйл. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 25.1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг Улаанбаатар хотын Захирагчийн	Тогтоол	ЗГ	УБЗАА-ЗУСХ, НЗДТГ-ын ТЗУХ, ХНУТ		НЗД-д тус албаны бүтэц орон тооны хязгаарын саналыг хүргүүлсэн.


		санал болгосноор Засгийн газар тогтооно.					
3.	Нийслэл хотыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэн, хуулийн этгээдийг шалгаруулах, дэмжих, урамшуулах журам	33 дугаар зүйл. Нийслэл хотыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих 33.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 33.1-д заасны дагуу хувь нэмэр оруулж, үр дүнд хүрсэн иргэн, хуулийн этгээдийг шалгаруулах, дэмжих, урамшуулах журмыг батална.	Журам	НИТХ	ТНБЧДЖБ ажлын хэсэг, ННЗБ-ууд	2021.11.30-ны дотор	
4.	Худалдаа үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам	МУЗЗНДНТУТХ-ийн 24 дүгээр зүйл. Нийслэлийн чиг үүрэг 24.1.9.худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт; 35 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх 35.1.16.худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;	Журам	НИТХ	ХЕМ-ийн А/232-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг.	2021.11.30-ны дотор	
ХОЕР. НИИСЛЭЛИЙН БОЛОН НИИСЛЭЛ ХОТЫН ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ЖАГСААЛТ							
1.	Нийслэл хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн нийтлэг журам	МУНУБХЭЗБТХ-ийн 8 дугаар зүйл. Нийслэл хотын чиг үүрэг 8.3.Нийслэл хот нь дараах бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ: 8.3.4.хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;	Журам	НИТХ	ХЕМ-ийн А/232-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, /НХХАГ, НШУҮИГ/	2022.01.25-ны дотор	

2.	Нийслэлд үйл ажиллагаа явуулах Сууц өмчлөгчдийн холбооны зохицуулалт, хяналт, хамтын ажиллагааны журам	8.3.9.сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зохицуулалт, хяналт;	Журам	НИТХ	ИХДБЧДЖБ ажлын хэсэг,	2022.01.25-ны дотор	
3.	Гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт	8.3.10.гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт, хяналт;	Журам	НИТХ	ТНБЧДЖБ ажлын хэсэг, /НЗДТГ-ын ХМХХ/	2022.01.25-ны дотор	НИТХ-ын 2017 оны 9/10 тогтоолоор батлагдсан журмыг шинэчлэх
4	Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, үржүүлэх, худалдаах, үржил хязнаарлах, эзэнгүй нохой муур устгах журам	8.3.3.орчны аюулгүй байдал	Журам	НИТХ	ХХОБМЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	
5	Нүхэн жорлон ашиглалтын журам	8.3.3 орчны аюулгүй байдал	Журам	НИТХ	ХХОБМЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	
6	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ашиглалтын дүрэм /сэтэлгээ, сүвлэгээ, орц, гарц, хайс хашлаганы засвар арчлалт, тээврийн хэрэгслийг ачих, буулгах үйлчилгээ/	8.2 Нийслэл хот нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ. 8.2.7 энэ хуульд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, автозам, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтцийн засвар арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ хамгаалалт 8.3.3. орчны аюулгүй байдал МУЗЗНДНТУТХ-ийн 24 дүгээр зүйл. Нийслэлийн чиг үүрэг	Дүрэм	НЗД	ИХДБЧДЖБ ажлын хэсэг,	2022.01.25-ны дотор	

		24.1.12. нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт 24.1.13. нийслэлийн авто зам, зогсоолын төлөвлөлт, байршил;					
7.	“Нийслэл Улаанбаатар хотын гудамж талбайн гэрэлтүүлгийн ашиглалт, үйлчилгээ болон хотын гудамж талбайн гэрэлтүүлгийн байгууламжийн ашиглалтын өртгийг тодорхойлох журам”-ыг шинэчлэх	8.3.3.орчны аюулгүй байдал; МУЗЗНДНТУТХ-ийн 24 дүгээр зүйл. Нийслэлийн чиг үүрэг 24.1.2.нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	Журам	НИТХ	ИХДБЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	Шилэн кабель, гэрэлтүүлгийн төлөвлөлт, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, захиалагч, хяналт хэрэгжүүлэх байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах
8.	Нийслэлийн нутаг дэвсгэрт хөшөө баримал байршуулахад дагаж мөрдөх журам	МУЗЗНДНТУТХ-ийн 24 дүгээр зүйл. Нийслэлийн чиг үүрэг 24.1.18.хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт	Журам	НИТХ	ТНБЧДЖБ ажлын хэсэг, /ХБХГ/	2022.01.25-ны дотор	
9.	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох	24.1.21.хог хаягдлын нэгдсэн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт;	Журам	НИТХ	ХХОБМЧДЖБ ажлын хэсэг,	2022.01.25-ны дотор	
10.	Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагаа зохион байгуулах журам	24.1.22.оршуулгын газрын нийтлэг зохицуулалт, менежмент.	Журам	НИТХ	ХХОБМЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	
11.	Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан болон иргэн, хуулийн этгээдийн хамтран эзэмших дундын шугам сүлжээ, барилга	24.1.10. орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ;	Журам	НИТХ	ИХДБЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	

	байгууламжийн ашиглалт, үйлчилгээний зохицуулалтын журам						
12.	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх хотын аж ахуй, инженерийн дэд бүтцийн байгууллагуудын нэгдсэн систем (ub engineering)-ийн ашиглалтын журам	24.1.14.харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт; 24.1.15.хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт;	Журам	НИТХ	ИХДБЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	
13	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам	МУНУБХЭЗБТХ-ийн 8 дугаар зүйл. Нийслэл хотын чиг үүрэг 8.3.Нийслэл хот нь дараах бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ. 8.3.3.орчны аюулгүй байдал;	Журам	НИТХ	ХХОБМЧДЖБ ажлын хэсэг	2022.01.25-ны дотор	НИТХТ-ийн 2007 оны 18 дугаар тогтоолоор баталсан журмыг шинэчлэх
НИЙТ: 17 Үүнээс: Тогтоол 1, дүрэм 1, журам 14, захирамж 1							

Хянасан: ДХХ-ийн дарга, ажлын хэсгийн ахлагч  Ц.Рэгзэдмаа

Нэгтгэсэн: ЗУСХ-ийн мэргэжилтэн, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга  Э.Уянга

